

**ҮНДСЭН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ АРД НИЙТИЙН САНАЛ АСУУЛГААР БАТАЛСНЫ ДАРАА АЛБАЖУУЛАХ, ХЭВЛЭН НИЙТЛЭХ, ХҮЧИН ТӨГӨЛДӨРТ ТООЦОХ ПРОЦЕССТОЙ ХОЛБООТОЙ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ**

(Харьцуулсан судалгаа)

*Г.Билгээ, Ц.Болормаа  
Р.Оргилмаа*

**АГУУЛГА**

**СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ**

**СУДАЛГААНЫ ХЭСЭГ**

Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг ард нийтийн санал асуулгаар баталсны дараа албажуулах, хэвлэн нийтлэх, хүчин төгөлдөрт тооцох процесстой холбоотой гадаадын зарим орны эрх зүйн зохицуулалт:

**1. Киргиз Улс**

- а) Бүгд Найрамдах Киргиз Улсын Үндсэн хууль
- б) БНКУ-ын Ард нийтийн санал асуулгын тухай үндсэн хуульчилсан хууль

**2. Эстони Улс**

- а) Бүгд Найрамдах Эстони Улсын Үндсэн хууль
- б) БНЭУ-ын Ард нийтийн санал асуулгын тухай хууль

**3. Ирланд Улс**

- а) Бүгд Найрамдах Ирланд Улсын Үндсэн хууль
- б) БНИУ-ын Ард нийтийн санал асуулгын тухай хууль (1994)<sup>419</sup>

**4. Франц Улс**

- а) Бүгд Найрамдах Франц Улсын Үндсэн хууль
- б) БНФУ-ын Үндэсний Ассамблейн дэгийн тухай хууль
- в) БНФУ-ын Үндсэн хуулийн зөвлөлийн тухай хууль

**5. Өмнөд Солонгос Улс**

- а) Бүгд Найрамдах Солонгос Улсын Үндсэн хууль
- б) БНСУ-ын Ард нийтийн санал асуулгын тухай хууль

**АШИГЛАСАН МАТЕРИАЛ**

<sup>419</sup> Referendum Act, 1994. [www.irishstatutebook.ie/eli/1994/act/12/enacted/en/print](http://www.irishstatutebook.ie/eli/1994/act/12/enacted/en/print)

## СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Төр, нийгэм, эдийн засаг, эрх зүйн системийн тогтвортой байдлыг хангах үүднээс Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийг хуульчлан тогтоосон тусгай дэгээр зохицуулдаг бөгөөд энэхүү зохицуулалт нь улс орон бүрт өөр өөрийн гэсэн онцлогтой байна.

Судалгаанд хамрагдсан 5 улсад Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг ард нийтийн санал асуулгаар эцэслэн баталсны дараа төрийн тэргүүн (Киргиз, Эстони, Ирланд, Өмнөд Солонгос), эсхүл үндсэн хуулийн шүүх (Франц) нь батламжлах (гарын үсэг зурах) буюу тунхаглан зарлаж байна.

Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль албан ёсоор хэвлэгдсэн өдрөөс (Киргиз), Сонгуулийн төв хороо ард нийтийн санал асуулгын дүнг хүлээн зөвшөөрснөөр (Өмнөд Солонгос), хуульд өөрт заасан хугацаанд (Ирланд), хууль тунхагласнаас хойш 3-аас доошгүй сарын дараа (Эстони) хүчин төгөлдөр үйлчилж эхлэхээр зохицуулсан бол Франц Улсад энэ хугацааг тодорхой заасан зохицуулалт олдоогүй болно. Үүнээс үзэхэд, улс орон бүр Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн тухай хуулийг батламжлах, хүчинтэйд тооцох хугацаа, дэг харилцан адилгүй байгаа нь харагдаж байна.

### **а) Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг ард нийтийн санал асуулгаар баталсаны дараа баталгаажуулах эрх бүхий субъектийн талаар:**

Киргизийн Ард нийтийн санал асуулгын тухай Үндсэн хуульчилсан хуулиар “**ард нийтийн санал асуулгаар батлагдсан шийдвэрт нэмэлт баталгаажуулалт шаардлагагүй**”-гээр бүх нийтээр дагаж мөрдөх бөгөөд Үндсэн хуульд зааснаар **Ерөнхийлөгч гарын үсэг зурна** (хугацаа заагаагүй). Тус улсын туршлагаас үзэхэд, 2016 оны 12 дугаар сарын 11-ны өдөр ард нийтийн санал асуулгаар Үндсэн хуульд өөрчлөлт оруулах тухай хууль<sup>420</sup> батлагдсан бөгөөд энэ хуулийн 2 дугаар зүйлд заасны дагуу Ерөнхийлөгч нь уг хуульд гарын үсэг зурж, тунхагласан байна.

**Ирланд Улсын Ерөнхийлөгч** нь Үндсэн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл Үндсэн хуульд нийцсэн эсэх, ард нийтийн санал асуулга хуулийн дагуу явагдсан эсэхийг хянан үзсэний дараа **гарын үсэг зурж, нийтлүүлнэ**.

Үндсэн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг **Өмнөд Солонгост Ерөнхийлөгч** нь нэгдсэн дүнг хүлээн авсан даруйдаа **батламжлах**, **Эстонид Ерөнхийлөгч** нь нэн даруй **тунхаглахыг** эдгээр улсын Үндсэн хууль, Ард нийтийн санал асуулгын тухай хуульд тус тус заасан байна.

**Франц Улсын** Үндсэн хуулийн зөвлөлийн тухай хуульд зааснаар **Үндсэн хуулийн зөвлөл** буюу Үндсэн хуулийн шүүх нь ард нийтийн санал асуулгаар дэмжигдсэн хуулийг **зарлигаар баталгаажуулахаар** (хугацаа заагаагүй) заасан байна.

### **б) Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг ард нийтийн санал асуулгаар баталсаны дараа хүчин төгөлдөр үйлчилж эхлэх хугацааны талаар:**

**Эстонид** ард нийтийн санал асуулгаар батлагдсан Үндсэн хуульд өөрчлөлт оруулах тухай хууль нь хуульд өөрт заасан хугацаанд хүчин төгөлдөр болох бөгөөд энэ хугацаа нь хуулийг тунхагласнаас хойш 3-аас доошгүй сар байхаар тус улсын Үндсэн хууль, Ард нийтийн санал асуулгын тухай хуульд тус тус заасан байна.

**Киргизид** ард нийтийн санал асуулгаар батлагдсан аливаа шийдвэр нь ард нийтийн санал асуулгын асуултын томьёололд тусгайлан заагаагүй бол **албан ёсоор хэвлэгдсэн өдрөөс** эхлэн хүчин төгөлдөр болно. Харин 2016 оны ард нийтийн санал асуулгаар батлагдсан Үндсэн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн тухайд уг хуулийн 2 дугаар зүйлд хууль албан ёсоор хэвлэгдсэн өдрөөс хойш **15 хоногийн дараа хүчин төгөлдөр болохоор** заасан байсан.

<sup>420</sup> О внесении изменений в Конституцию Кыргызской Республики от 28 декабря 2016 года № 218.

**Өмнөд Солонгосын** Үндсэн хуульд зааснаар Сонгуулийн төв хорооноос ард нийтийн санал асуулгын дүнг **хүлээн зөвшөөрснөөр** Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлт хүчин төгөлдөр болно.

**Ирланд болон Францад** Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр үйлчилж эхлэх хугацааг тодорхой заагаагүй байна.

Ирландын хувьд ард нийтийн санал асуулгын урьдчилсан дүн гарсны дараа сонгуулийн хэсэгт томилогдсон эрх бүхий албан тушаалтан<sup>421</sup> ард нийтийн санал асуулгын дүнгийн тухай түр гэрчилгээ олгож, албан ёсны сонинд нийтэлнэ. Ийнхүү нийтэлснээс хойш 7 хоногийн дотор иргэдээс ард нийтийн санал асуулгын талаар Дээд шүүхэд гомдол гаргаж болох бөгөөд хэрэв гомдол гараагүй, эсхүл гомдлыг хэрэгсэхгүй болсон тохиолдолд ард нийтийн санал асуулгын тухай гэрчилгээг албан ёсны болгоно.

## СУДАЛГААНЫ ХЭСЭГ

### ҮНДСЭН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ АРД НИЙТИЙН САНАЛ АСУУЛГААР БАТАЛСНЫ ДАРАА АЛБАЖУУЛАХ, ХЭВЛЭН НИЙТЛЭХ, ХҮЧИН ТӨГӨЛДӨРТ ТООЦОХ ПРОЦЕССТОЙ ХОЛБООТОЙ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Судалгаанд Эстони, Киргиз, Ирланд, Франц, Өмнөд Солонгос зэрэг орнуудыг хамруулсан бөгөөд эдгээр орнуудад Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг ард нийтийн санал асуулгаар батлахтай холбоотой харилцааг дор дурдсан хуулиудаар зохицуулж байна. Үүнд:

1. Киргиз: - Үндсэн хууль<sup>422</sup>;  
- Ард нийтийн санал асуулгын тухай Үндсэн хуульчилсан хууль<sup>423</sup>;
2. Эстони: - Үндсэн хууль<sup>424</sup>;  
- Ард нийтийн санал асуулгын тухай хууль<sup>425</sup>;
3. Ирланд: - Үндсэн хууль<sup>426</sup>;  
- Ард нийтийн санал асуулгын тухай хууль, 1994<sup>427</sup>;
4. Франц: - Үндсэн хууль<sup>428</sup>;  
- Үндэсний Ассамблейн дэгийн тухай хууль<sup>429</sup>;  
- Үндсэн хуулийн зөвлөлийн тухай хууль<sup>430</sup>;
5. Өмнөд Солонгос: - Үндсэн хууль<sup>431</sup>;  
- Ард нийтийн санал асуулгын тухай хууль<sup>432</sup>;  
- Ард нийтийн санал асуулгын тухай хуулийг хэрэгжүүлэх журам<sup>433</sup>;  
- Үндэсний Ассамблейн тухай хууль<sup>434</sup>.

<sup>421</sup> Сонгуулийн хэсэгт томилогдсон эрх бүхий албан тушаалтан - ард нийтийн санал асуулгын үед сонгуулийн хэсэгт томилогдон ажиллах эрх бүхий албан тушаалтан (1994 оны Ард нийтийн санал асуулгын тухай хуулийн 15 дугаар зүйл).

<sup>422</sup> Конституция Кыргызской Республики. <http://cbd.minjust.gov.kg/act/view/ru-ru/202913?cl=ru-ru>

<sup>423</sup> Конституционный закон Кыргызской Республики от 31 октября 2016 года № 173-О референдуме Кыргызской Республики. <http://cbd.minjust.gov.kg/act/view/ru-ru/111452>

<sup>424</sup> Конституция Эстонской Республики. Принята 28 июня 1992 года. Вступила в силу 3 июля 1992 года. <https://www.president.ee/ru/republic-of-estonia/constitution-of-the-republic-of-estonia/index.html>

<sup>425</sup> Закон о референдуме (Всенародном голосовании). Принят 13 марта 2002 года. [http://estonia.news-city.info/docs/sistemsw/dok\\_iegdao/page3.htm](http://estonia.news-city.info/docs/sistemsw/dok_iegdao/page3.htm)

<sup>426</sup> Constitution of Ireland. [www.irishstatutebook.ie/eli/cons/en](http://www.irishstatutebook.ie/eli/cons/en)

<sup>427</sup> Referendum Act, 1994. [www.irishstatutebook.ie/eli/1994/act/12/enacted/en/print](http://www.irishstatutebook.ie/eli/1994/act/12/enacted/en/print)

<sup>428</sup> Constitution of the French Republic. [www.constituteproject.org/constitution/France\\_2008?lang=en](http://www.constituteproject.org/constitution/France_2008?lang=en)

<sup>429</sup> Rules of Procedure of the National Assembly

[www.legislationline.org/download/action/download/id/2084/file/France\\_Rules\\_Procedure\\_NationalAssembly\\_2007htm/preview](http://www.legislationline.org/download/action/download/id/2084/file/France_Rules_Procedure_NationalAssembly_2007htm/preview)

<sup>430</sup> Institutional Act on the Constitutional Council.

[www.conseil-constitutionnel.fr/conseil-constitutionnel/root/bank\\_mm/anglais/texts.pdf](http://www.conseil-constitutionnel.fr/conseil-constitutionnel/root/bank_mm/anglais/texts.pdf)

<sup>431</sup> Constitution of the Republic of Korea. [www.constituteproject.org/constitution/Republic\\_of\\_Korea\\_1987?lang=en](http://www.constituteproject.org/constitution/Republic_of_Korea_1987?lang=en)

<sup>432</sup> Referendum Act. [https://elaw.klri.re.kr/eng\\_service/lawView.do?hseq=39981&lang=ENG](https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=39981&lang=ENG)

<sup>433</sup> Enforcement Decree of the Referendum Act.

[https://elaw.klri.re.kr/eng\\_service/lawView.do?hseq=44781&lang=ENG](https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=44781&lang=ENG)

<sup>434</sup> National Assembly Act. [https://elaw.klri.re.kr/eng\\_service/lawView.do?hseq=44198&lang=ENG](https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=44198&lang=ENG)

## **1.КИРГИЗ УЛС**

### **а) Үндсэн хууль:**

#### **9 дүгээр бүлэг. Үндсэн хуульд өөрчлөлт оруулах журам**

114.1.Үндсэн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг Жогорку Кенеш (Парламент)-ээс тогтоосноор ард нийтийн санал асуулгаар баталж болно.

114.2.Парламентын төлөөлөгчдийн олонхын саналаар, эсхүл 300 мянган сонгогчдын санаачилснаар Үндсэн хуулийн 3, 4, 5, 6, 7, 8 дугаар бүлгийн заалтуудад өөрчлөлт оруулна.

114.3.Парламент нь Үндсэн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг өргөн барьсан өдрөөс хойш 6 сарын дотор батална.

Парламент нь Үндсэн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 3-аас доошгүй удаа хэлэлцэх ба хэлэлцүүлэг хооронд завсарлах хугацаа 2 сар байна. Үндсэн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Парламентын нийт төлөөлөгчдийн 2/3-оос доошгүйн олонхын саналаар батална.

Парламентын нийт төлөөлөгчдийн 2/3-оос доошгүйн санаачилж Үндсэн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг ард нийтийн санал асуулгаар оруулна.

114.5.Үндсэн хуульд өөрчлөлт оруулах тухай хуульд Ерөнхийлөгч гарын үсэг зурна.

### **б) Ард нийтийн санал асуулгын тухай Үндсэн хуульчилсан хууль:**

7.1.Ард нийтийн санал асуулгыг Үндсэн хуульд өөрчлөлт оруулах тухай хууль, үндсэн хуульчилсан хууль болон бусад хуулийн төслүүд, мөн улс орны бусад чухал асуудлаар явуулна.

31.3.Санал асуулгын хуудсанд ард нийтийн санал асуулгаар оруулж байгаа асуудлын текст, “зөвшөөрнө”, “татгалзана” гэсэн хариултын хувилбарыг заах ба түүний доор хоосон дөрвөлжин байрлуулна.

Хэрэв ард нийтийн санал асуулгад өөр хувилбарын асуулт орох бол “Бүх хувилбараас татгалзана” гэсэн санал илэрхийлэх хувилбарыг заана. Хувилбар бүрийн баруун талд хоосон дөрвөлжин байрлуулах ба энэ тохиолдолд ард нийтийн санал асуулгад оролцогч нь зөвхөн нэг хувилбарыг сонгох эрхтэй.

Хэрэв ард нийтийн санал асуулгаар хэд хэдэн асуулт орох бол санал асуулгын хуудас тус бүрт нэг асуулт оруулна. Санал асуулгын хуудсанд мөн “Бүх хувилбараас татгалзана” гэсэн санал илэрхийлэх хувилбарыг заана. Асуулт бүрийн баруун талд хоосон дөрвөлжин байрлуулах ба энэ тохиолдолд ард нийтийн санал асуулгад оролцогч нь бусад асуултуудын хариултаас үл хамааран асуулт бүрт хариулна.

37.1.Сонгуулийн төв хороо нь ард нийтийн санал асуулга явуулсан өдрөөс хойш 35 хоногийн дотор орон нутгийн сонгуулийн хороодоос ирүүлсэн санал асуулгын дүнг нэгтгэнэ.

Сонгуулийн төв хороо нэгдсэн дүнгийн хурал заавал хийх ба хурлаар ард нийтийн санал асуулгыг бэлтгэх, зохион байгуулах явцад гарсан зөрчлийн талаар хүлээн авсан бүх өргөдөл (гомдол)-ийг хэлэлцэж, өргөдөл (гомдол) тус бүрээр шийдвэр гаргана.

37.3.Жагсаалтад бүртгэгдсэн оролцогчдын 30-аас дээш хувь нь ард нийтийн санал асуулгад оролцсон тохиолдолд Сонгуулийн төв хорооноос ард нийтийн санал асуулгыг хүчинтэйд тооцно.

Хэрэв ард нийтийн санал асуулгад оролцогсдын талаас дээш хувь нь асуултыг дэмжсэн бол баталсанд тооцно.

Хэрэв хариултын хувилбаруудын аль нь ч ард нийтийн санал асуулгад оролцогчдын талаас дээш хувийн санал аваагүй бол Сонгуулийн төв хороо нь ард нийтийн санал асуулгад оролцогсдын хамгийн олон санал авсан хариултын хувилбарыг хүлээн зөвшөөрнө.

Хэрэв ард нийтийн санал асуулгад оролцогчдын талаас дээш хувь нь хариултын бүх хувилбараас татгалзсан бол Сонгуулийн төв хороо нь ард нийтийн санал асуулгаар орсон бүх асуултаас татгалзсанд тооцно.

39.1.Сонгуулийн ерөнхий хороо нь хэсгүүдээс ирсэн саналын дүнг Сонгуулийн ерөнхий хорооны цахим хуудсанд нэн даруй байршуулна.

Сонгуулийн ерөнхий хорооны цахим хуудсанд байршуулсан саналын дүн нь урьдчилсан дүн бөгөөд эрх зүйн үр дагавар агуулаагүй болно.

39.2.Сонгуулийн ерөнхий хороо нь ард нийтийн санал асуулгын дүнг гаргаснаас хойш нэг өдрийн дотор ард нийтийн санал асуулгын нэгдсэн дүнг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд нийтэлнэ.

39.3.Сонгуулийн ерөнхий хороо нь ард нийтийн санал асуулгын нэгдсэн дүнг гаргасан өдрөөс хойш 14 хоногийн дотор ард нийтийн санал асуулгын дүн, ард нийтийн санал асуулгын асуултад “зөвшөөрнө”, “татгалзана” гэж санал өгсөн оролцогчдын дүнг албан ёсоор хэвлүүлнэ.

39.5.Ард нийтийн санал асуулгаар батлагдсан шийдвэр нь ард нийтийн санал асуулгын асуултын томъёололд заагаагүй бол албан ёсоор хэвлэгдсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

40.1.Ард нийтийн санал асуулгаар батлагдсан шийдвэрт нэмэлт баталгаажуулалт шаардлагагүй бөгөөд бүх нийтээр заавал дагаж мөрдөнө, Бүгд Найрамдах Киргиз Улсын нийт нутаг дэвсгэрт үйлчилнэ.

## **2.ЭСТОНИ УЛС**

### **а) Үндсэн хууль:**

105.Рийгикогу (Парламент) нь улс орны амьдралд хамаарах хуулийн төсөл, эсхүл бусад асуудлыг ард нийтийн санал асуулгаар батлуулах эрхтэй.

Санал асуулгад оролцогчдын олонхын саналаар иргэдийн шийдвэр гарна.

Ард түмний санал асуулгаар батлагдсан хуулийг Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч нэн даруй тунхаглана. Ард нийтийн санал асуулгын дүнг төрийн байгууллагууд заавал биелүүлнэ.

Хэрэв ард нийтийн санал асуулгаар оруулсан хуулийн төсөлд “тийм” гэж олонх санал өгөөгүй бол Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч нь Парламентын ээлжит бус сонгуулийг зарлана.

162.Үндсэн хуулийн “Нийтлэг үндэслэл” гэсэн 1 дүгээр бүлэг, “Үндсэн хуульд өөрчлөлт оруулах” гэсэн 15 дугаар бүлэгт зөвхөн ард нийтийн санал асуулгаар нэмэлт, өөрчлөлт оруулна.

163.Дараах журмаар батлагдсан хуулиар Үндсэн хуульд өөрчлөлт оруулна:

- 1) ард нийтийн санал асуулгаар;
- 2) Парламентын дараалсан 2 бүрэн эрхийн бүрэлдэхүүнээр;
- 3) Парламент нэн яаралтай дэгээр.

Үндсэн хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийн хэлэлцүүлгийг 3 үе шаттай хэлэлцэнэ. Ингэхдээ хуулийн төслийн анхны болон хоёр дахь хэлэлцүүлэг хооронд завсарлах хугацаа 3-аас доошгүй сар, хоёр дахь болон эцсийн хэлэлцүүлэг хооронд завсарлах хугацаа 1-ээс доошгүй сар байна. Үндсэн хуульд өөрчлөлт оруулах хуулийг эцсийн хэлэлцүүлгээр шийдвэрлэнэ.

164.Үндсэн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг ард нийтийн санал асуулгаар оруулахад Парламентын бүрэлдэхүүний 2/3-ын саналаар шийдвэрлэнэ. Парламент ийнхүү шийдвэрлэсэн өдрөөс хойш 3-аас доошгүй сарын дараа ард нийтийн санал асуулгыг явуулна.

167.Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч нь Үндсэн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг тунхаглах ба хуульд өөрт заасан хугацаанд хүчин төгөлдөр болох бөгөөд энэ хугацаа нь хуулийг тунхагласнаас хойш 3-аас доошгүй сарын дараа байна.

### **б) Ард нийтийн санал асуулгын тухай хууль:**

1.1.Парламентын шийдвэрээр Үндсэн хуулийн 1, 15 дугаар бүлэгт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг ард нийтийн санал асуулгаар оруулна.

30.1.Хэрэв ард нийтийн санал асуулгаар хуулийн төслийг оруулах бол санал асуулгын хуудсанд хуулийн төслийн нэр, эсхүл Парламентын шийдвэрээр хуулийн төсөл, “Та хуулийн төслийг батлах уу?” гэсэн асуулт болон дараагийн мөрөнд “тийм”, эсхүл “үгүй” гэсэн хариултын хувилбарыг бичнэ.

63.1.Сонгуулийн хороо нь ард нийтийн санал асуулгын дүнг олон нийтэд зарласан өдөр ард нийтийн санал асуулгаар батлагдсан хууль болон ард нийтийн санал асуулгын дүнг Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгчид танилцуулна. Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч нь хуулийг нэн даруй тунхаглана.

63.2.Ард нийтийн санал асуулгаар батлагдсан Үндсэн хуульд өөрчлөлт оруулах тухай хууль нь хуульд өөрт заасан хугацаанд хүчин төгөлдөр болох бөгөөд энэ хугацаа нь хуулийг тунхагласнаас хойш 3-аас доошгүй сарын дараа байна.

64.Хэрэв ард нийтийн санал асуулгаар оруулсан хуулийн төсөлд “тийм” гэж олонх санал өгөөгүй бол Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч нь ард нийтийн санал явуулах тухай шийдвэр гаргасан Парламентын бүрэн эрх дуусаагүй тохиолдолд Парламентын сонгуулийн тухай хуульд заасан журмын дагуу Парламентын ээлжит бус сонгуулийг зарлана.

## **3.ИРЛАНД**

### **а) Үндсэн хууль:**

46.1.Үндсэн хуульд өөрчлөлт, эсхүл нэмэлт, эсхүл зарим зүйл, заалтыг хүчингүй болгох замаар өөрчлөлт оруулах бол энэ зүйлд заасан журмыг баримтална.

46.2.Үндсэн хуульд өөрчлөлт оруулах тухай бүх саналыг Төлөөлөгчдийн Танхимд хуулийн төсөл хэлбэрээр өргөн баригдах бөгөөд Парламентын хоёр танхимаар батлагдсан, эсхүл батлагдсанд тооцсон гэж үзвэл ард нийтийн санал асуулгын тухай хууль тогтоомжийн дагуу ард нийтийн санал асуулгаар оруулж ард түмнээр батлуулна.

46.3.Ийм хуулийн төслийг “Үндсэн хуульд өөрчлөлт оруулах тухай” гэж нэрлэнэ.

46.4.Үндсэн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд бусад аливаа агуулагыг оруулахгүй.

46.5.Ерөнхийлөгч нь Үндсэн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл Үндсэн хуулийн энэ зүйлд заасан журмыг хангасан эсэх, хуулийн төслийг Үндсэн хуулийн 47 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу ард түмнээс баталсан эсэхийг хянан үзсэн даруйдаа хуулд гарын үсэг зурна. Үүний дараа Ерөнхийлөгч Үндсэн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг нийтлүүлнэ.

47.1.Үндсэн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг ард түмнээр батлуулахын тулд ард нийтийн санал асуулгаар оруулна. Ард нийтийн санал асуулгаад оролцогсдын олонх Үндсэн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг дэмжсэн бол Үндсэн хуулийн 46 дугаар зүйлд заасны дагуу ард түмэн баталсанд тооцно.

### **б) Ард нийтийн санал асуулгын тухай хууль (1994)<sup>435</sup>:**

40.1.Сонгуулийн хэсэгт томилогдсон эрх бүхий албан тушаалтан<sup>436</sup> нь орон нутгийн бүх хэсгүүдээс энэ хуулийн 37 дугаар зүйлд заасан тайланг хүлээн авч нэгдсэн тайлан гаргах бөгөөд ард нийтийн санал асуулгын дүнгийн тухай түр гэрчилгээ олгоно.

<sup>435</sup> Referendum Act, 1994. [www.irishstatutebook.ie/eli/1994/act/12/enacted/en/print](http://www.irishstatutebook.ie/eli/1994/act/12/enacted/en/print)

<sup>436</sup> Сонгуулийн хэсэгт томилогдсон эрх бүхий албан тушаалтан - ард нийтийн санал асуулгын үед сонгуулийн



40.2. Сонгуулийн хэсэгт томилогдсон эрх бүхий албан тушаалтан нь ард нийтийн санал асуулгын дүнгийн тухай түр гэрчилгээ олгосны дараа түр гэрчилгээний хуулбарыг Iris Oifigiuil<sup>437</sup> сонинд нийтлүүлнэ.

40.3. Дээд шүүх ард нийтийн санал асуулгын дүнгийн тухай түр гэрчилгээг албан ёсны болгосны дараа сонгуулийн хэсэгт томилогдсон эрх бүхий албан тушаалтан нь гэрчилгээг батламжлах бөгөөд гэрчилгээний хуулбарыг Ерөнхийлөгч болон Taoiseach-д хүргүүлнэ.<sup>438</sup>

41. Дээд шүүхийн мастер<sup>439</sup> нь энэ хуулийн 58 дугаар зүйлд заасны дагуу ард нийтийн санал асуулгын талаар гомдол гарсан эсэх талаар сонгуулийн хэсгийн эрх бүхий албан тушаалтанд нэн даруй мэдэгдэнэ.

42.1. Ард нийтийн санал асуулгын дүнгийн тухай түр гэрчилгээний талаар Дээд шүүхэд энэ хуулийн дагуу гомдол гаргаж болно.

42.2. Дээд шүүхэд ард нийтийн санал асуулгын дүнгийн талаарх гомдлыг Ард нийтийн санал асуулгын тухай гэрчилгээг Iris Oifigiuil сонинд нийтэлснээс хойш 7 хоногийн дотор гаргана.

#### **4. ФРАНЦ УЛС**

##### **а) Үндсэн хууль:**

42.3. Засгийн газар болон парламентын гишүүдийн санаачилсан хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг харьяалах танхимд хэлэлцүүлэхээр хуваарилснаас хойш 6 долоо хоногийн дараа хийнэ. Хуулийн төслийг өөр танхимаар хэлэлцүүлэхээр шилжүүлснээс хойш 4 долоо хоногийн дараа хэлэлцэнэ.

89. Парламентын гишүүд болон Ерөнхий сайдын санал болгосноор Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл санаачлах эрхтэй.

Засгийн газар болон парламентын гишүүдийн санаачилсан Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг энэ хуулийн 42 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан хугацаанд хоёр танхимаар хэлэлцэн батална. Төсөл нь ард нийтийн санал асуулгаар дэмжигдэн эцэслэгдэнэ.

Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч нь Засгийн газраас санаачилсан Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг Конгрессын (хамтарсан) хуралдаанаар хэлэлцүүлэхээр шилжүүлсэн бол санал өгсөн гишүүдийн 3/5-ын саналаар дэмжигдсэнд тооцогдоно. Энэ тохиолдолд ард нийтийн санал асуулга явуулахгүй. Конгрессын товчооны үүргийг Үндэсний Ассамблей гүйцэтгэнэ.

##### **б) Үндэсний ассамблейн дэгийн тухай хууль:**

##### **Х хэсэг. Ард нийтийн санал асуулга явуулахыг санаачлах**

126.1. Засгийн газар болон Үндэсний Ассамблейн гишүүдийн санаачилсан Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Үндсэн хуулийн 89 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу бусад хуулийн төслүүдийн адил хэлэлцэж санал өгнө.

126.2. Үндэсний Ассамблей нь хуулийн төслийг Сенатаар батлах журмын дагуу

---

хэсэгт томилогдон ажиллах эрх бүхий албан тушаалтан (1994 оны Ард нийтийн санал асуулгын тухай хуулийн 15 дугаар зүйл).

<sup>437</sup> Iris Oifigiuil (Official Journal) – Ирландын Засгийн газрын албан ёсны сонин.

<sup>438</sup> The Department of the Taoiseach (Irish: *Roinn an Taoisigh*) is the government department of the Taoiseach<sup>[1]</sup> of Ireland. It is based in Government Buildings, the headquarters of the Government of Ireland, on Merrion Street in Dublin.

Министерство Премьер-министра Ирландии (ирл. *Roinn an Taoisigh*) — министерство созданное в составе Правительства Ирландии, которое обеспечивает деятельность главы исполнительной власти Республики Ирландия - ирл. *Taoiseach*.<sup>[1]</sup>

<sup>439</sup> Дээд Шүүхийн мастер нь Ирландын тойргийн шүүхийн нарийн бичгийн даргатай адил чиг үүргийг хэрэгжүүлэх бөгөөд иргэний хэргээр захиргааны шинжтэй асуудал шийдвэрлэх эрх мэдэлтэй байдаг. Эх сурвалж: <https://lauraonlaw.wordpress.com/2012/09/26/structure-function-jurisdiction-of-the-high-court-of-ireland/>

баталсан тохиолдолд хуулийн төслийг Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгчид шилжүүлнэ.

**в) Үндсэн хуулийн зөвлөлийн тухай хууль:**

49.Үндсэн хуулийн зөвлөл нь ард нийтийн санал асуулгын ерөнхий дүнд хяналт тавьж ажиллана.

51.Үндсэн хуулийн зөвлөл нь ард нийтийн санал асуулгын дүнг олон нийтэд зарлана. Үндсэн хуулийн зөвлөл нь ард нийтийн санал асуулгаар дэмжигдсэн хуулийг зарлигаар баталгаажуулна.

**5.ӨМНӨД СОЛОНГОС**

**а) Үндсэн хууль:**

**10 дугаар бүлэг. Үндсэн хуулийн өөрчлөлт**

128.1.Үндэсний Ассамблейн нийт гишүүдийн олонх, эсхүл Ерөнхийлөгч Үндсэн хуульд өөрчлөлт оруулахыг санаачилна.

129.Ерөнхийлөгчийн Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг 20 болон түүнээс дээш хоногийн хугацаагаар хэвлэн нийтэлнэ.

130.1.Нэмэлт, өөрчлөлт оруулах тухай төслийг нийтэд зарласнаас хойш 60 хоногийн дотор Үндэсний Ассамблейгаар хэлэлцэх эсэхийг хэлэлцэж, Үндэсний Ассамблейн нийт гишүүдийн 2/3-ын саналаар шийдвэрлэнэ.

130.2.Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг Үндэсний Ассамблейгаар хэлэлцэн шийдвэрлэснээс хойш 30 хоногийн дотор ард нийтийн санал асуулга явуулна. Санал асуулгын дүнг Үндэсний Ассамблейн сонгуульд оролцох эрх бүхий сонгогчдын олонхын саналаар батална.

130.3.Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу санал асуулгын дүнг хүлээн зөвшөөрснөөр Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлт хүчин төгөлдөр болж, Ерөнхийлөгч нэн даруй батламжилна.

**б) Ард нийтийн санал асуулгын тухай хууль:**

**IX бүлэг Санал асуулгын эцсийн дүн**

**87 дугаар зүйл (Дүнг нэгтгэх)**

1.Сонгуулийн төв хороо нь Хот (болон хөдөө орон нутгийн) сонгуулийн хороодоос ирүүлсэн дүнг хүлээн авч санал асуулгад оролцох иргэдийн тоо, оролцсон иргэдийн тоо, дэмжсэн болон эсэргүүцсэн, түүнчлэн хүчингүй саналын дүнг нэн даруй нэгтгэн гаргана.

2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар дүнг нэгтгэн гаргахад Сонгуулийн төв хорооны гишүүдийн ихэнх нь байлцах шаардлагатай.

**89 дүгээр зүйл (Нэгдсэн дүнг хэвлэх болон мэдэгдэх)**

Сонгуулийн төв хороо нь 87 дугаар зүйлд заасны дагуу санал асуулгын дүнг нэгтгэсний дараа хэвлэн нийтэлж, Ерөнхийлөгч болон Үндэсний Ассамблейн даргад мэдэгдэнэ.

**91 дүгээр зүйл (Эцсийн дүнг батламжлах)**

Ерөнхийлөгч нь энэ хуулийн 89, 90 дүгээр зүйлд заасны дагуу ард нийтийн санал асуулгын нэгдсэн дүнг хүлээн авсан даруйдаа батламжилна.



## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Referendum Act, 1994. [www.irishstatutebook.ie/eli/1994/act/12/enacted/en/print](http://www.irishstatutebook.ie/eli/1994/act/12/enacted/en/print)
- О внесении изменений в Конституцию Кыргызской Республики от 28 декабря 2016 года № 218.
- Конституция Кыргызской Республики. <http://cbd.minjust.gov.kg/act/view/ru-ru/202913?cl=ru-ru>
- Конституционный закон Кыргызской Республики от 31 октября 2016 года № 173 О референдуме Кыргызской Республики. <http://cbd.minjust.gov.kg/act/view/ru-ru/111452>
- Конституция Эстонской Республики. Принята 28 июня 1992 года. Вступила в силу 3 июля 1992 года. <https://www.president.ee/ru/republic-of-estonia/constitution-of-the-republic-of-estonia/index.html>
- Закон о референдуме (Всенародном голосовании). Принят 13 марта 2002 года. [http://estonia.news-city.info/docs/sistemsw/dok\\_iegdao/page3.htm](http://estonia.news-city.info/docs/sistemsw/dok_iegdao/page3.htm)
- Constitution of Ireland. [www.irishstatutebook.ie/eli/cons/en](http://www.irishstatutebook.ie/eli/cons/en)
- Referendum Act, 1994. [www.irishstatutebook.ie/eli/1994/act/12/enacted/en/print](http://www.irishstatutebook.ie/eli/1994/act/12/enacted/en/print)
- Constitution of the French Republic. [www.constituteproject.org/constitution/France\\_2008?lang=en](http://www.constituteproject.org/constitution/France_2008?lang=en)
- Rules of Procedure of the National Assembly [www.legislationline.org/download/action/download/id/2084/file/France\\_Rules\\_Procedure\\_NationalAssembly\\_2007htm/preview](http://www.legislationline.org/download/action/download/id/2084/file/France_Rules_Procedure_NationalAssembly_2007htm/preview)
- Institutional Act on the Constitutional Council. [www.conseil-constitutionnel.fr/conseil-constitutionnel/root/bank\\_mm/anglais/texts.pdf](http://www.conseil-constitutionnel.fr/conseil-constitutionnel/root/bank_mm/anglais/texts.pdf)
- Constitution of the Republic of Korea. [www.constituteproject.org/constitution/Republic\\_of\\_Korea\\_1987?lang=en](http://www.constituteproject.org/constitution/Republic_of_Korea_1987?lang=en)
- Referendum Act. [https://elaw.klri.re.kr/eng\\_service/lawView.do?hseq=39981&lang=ENG](https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=39981&lang=ENG)
- Enforcement Decree of the Referendum Act. [https://elaw.klri.re.kr/eng\\_service/lawView.do?hseq=44781&lang=ENG](https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=44781&lang=ENG)
- National Assembly Act. [https://elaw.klri.re.kr/eng\\_service/lawView.do?hseq=44198&lang=ENG](https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=44198&lang=ENG)
- Referendum Act, 1994. [www.irishstatutebook.ie/eli/1994/act/12/enacted/en/print](http://www.irishstatutebook.ie/eli/1994/act/12/enacted/en/print)
- Iris Oifigiuil (Official Journal) – Ирландын Засгийн газрын албан ёсны сонин.
- The Department of the Taoiseach (Irish: *Roinn an Taoisigh*) is the government department of the Taoiseach<sup>[1]</sup> of Ireland. It is based in Government Buildings, the headquarters of the Government of Ireland, on Merrion Street in Dublin.
- Министерство Премьер-министра Ирландии (ирл. *Roinn an Taoisigh*) — министерство созданное в составе Правительства Ирландии, которое обеспечивает деятельность главы исполнительной власти Республики Ирландия - ирл. *Taoiseach*.<sup>[1]</sup>

УИГ.МН  
СУДАЛГААНЫ САН